



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 87

Даланзадгад сум

“Харшлын эсрэг” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2. “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Харшлын эсрэг” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Эрүүл мэндийн салбар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

462210199



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар сарын 17-ны
өдрийн 87 дугаар тогтоолын хавсралт



“Харшлын эсрэг” хөтөлбөр (2021-2024 он)

Нэг. Нийтлэг үндэслэл:

XX зууны эхэн үеэс харшлын өвчин /астма, атопийн дерматит, барууны оронд архагшин тархаж байгаа хоолны харшил гэх мэт/ тасралтгүй өссөн хандлагатай байна

Харшлын өвчин нь байгаль, нийгмийн хүчин зүйлүүд болон хувь хүний генийн мэдрэмтгий чанарын харилцан үйлчлэлийн үр дүнд бий болдог. Харшлын өвчинд үзүүлэх генийн нөлөө 50% ба удамшлын мэдрэгших чадвар 36-79% байдаг. АНУ-ын хамгийн зардал өндөртэй архаг өвчний ангиллын зургаа дугаарт бичигдэж байна.

Дэлхийн харшлын нийгэмлэгийн 2013 оноос хойших тоон мэдээгээр 400 сая хүн харшлын ринит, 300 сая хүн харшилт хэлбэрийн гуурсан хоолойн багтраа, 200-250 сая хүн хүнсний харшлаар өвчилсөн байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас (ARIAWHO) 2010 онд Паджаджараны их сургуулийн анагаах ухааны сургуулийн багш оюутнууд харшлын ринитын тархалтыг судлахад судалгаанд хамрагдсан хүмүүсийн дунд тархалтын түвшин 38.2% байсан ба Азийн хүн амын харшлын өвчний тархалттай ойролцоо үзүүлэлттэй байсан.

Дэлхийн харшлын тухай 2008 оны тайланд Азийн олон орон ялангуяа бага, дунд орлоготой орнуудад нийгэм, эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор харшлын ринитийн тархалтын түвшин 5-45% хүртэл нэмэгдсэн байна.

Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн дундах харшлын ринит, астмын тархалтыг 2014 онд судалсан С.Мөнхбаярлах, Д.Сарангэрэл, Л.Наранцэцэг нар хүн амд суурилсан астма, харшлын ринит өвчлөл болон эрсдэлт хүчин зүйлсийг судалсан байна. Үүнд Улаанбаатар хотын 20-иос дээш насны насанд хүрэгчдийн дунд харшлын ринит 23,6%, харшлын риноконъюнктивит 14,2%-тай байсан байна. 2019 оны байдлаар харшлын өвчлөл улсын хэмжээнд 19195, АӨСҮТ-д 5352 бүртгэгдсэн байна.

Өмнөговь аймгийн хувьд сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, байгалийн баялаг ашиглалтын улмаас үүссэн тоосжилт нь жил тутам өсөн нэмэгдэж байгаа ба хүн амд амьсгалын замын харшил үүсгэх эрсдэлийг нэмж байна.

Өмнөговь аймгийн хүн амын дунд сүүлийн 10 жилийн байдлаар амьсгалын замын өвчлөл эрс нэмэгдэж, нийт өвчлөлийн тэргүүлэх 5 өвчлөлд орсон бөгөөд 2005 онд 10000 хүнд 1336 тохиолдож, 2014 онд 2247 болон өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс харшлын ринит оношоор сүүлийн 5 жилийн дотор 84 байсан бол 508 хүртэл тохиолдлын тоо ихэсч, жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь орон нутагт тулгамдсан асуудал болж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэхээр тусгасан. Өмнөговь аймгийн 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрт “Харшлын эсрэг” хөтөлбөр хэрэгжүүлэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2/4 тогтоолоор батлагдсан.

Иймд харшлын өвчлөлийн үндсэн шалтгаан болох орчны бохирдол, тоосжилтыг бууруулж, ногоон байгууламжийг зохистой бий болгох замаар харшил төрүүлэгчийг бууруулах, иргэдийн эрүүл, зөв дадал, хоол хүнсний зохистой хэрэглээ, мэдлэг хандлагыг дээшлүүлж харшлын өвчнөөс бүрэн урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн салбарт харшилт өвчний эрт илрүүлгийг сайжруулах, оношлох, эмчлэх зайлшгүй шаардлагатай байгаа тул хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Мөн аймгийн хэмжээнд харшлын эсрэг хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд салбар дундын хамтын оролцоог хангах, хамтран ажиллах нь илүү үр дүнтэй байх юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа:

2.1. Хөтөлбөрийн Зорилго:

Хүн амыг харшлын өвчлөлөөс анхдагч, хоёрдогчоор урьдчилан сэргийлэх, иргэдийн мэдлэг, хандлагыг сайжруулах, харшил, харшилт өвчний оношилгоо, эмчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар харшлын шалтгаант өвчлөлийг бууруулна.

2.2. Зорилтууд:

Зорилт 1: Хүн амын дунд харшлын шалтгаант өвчнөөс урьдчилан сэргийлэхэд эрх зүй, тогтвортой санхүүгийн бодлогоор дэмжих, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах, харшил төрүүлэгчийг бууруулснаар эрүүл орчин бий болгох /анхдагч, хоёрдогч, гуравдагч урьдчилан сэргийлэх чиглэл/

Зорилт 2: Ард иргэдийн дунд харшлын талаар эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, сургалт сурталчилгааг тасралтгүй явуулах, харшлын шалтгаант эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, сэдрэлийг бууруулах талаар мэдлэг, зөв амьдрах дадал бий болгох (анхдагч, хоёрдогч, гуравдагч урьдчилан сэргийлэх чиглэл)

Зорилт 3: Харшил, харшлын шалтгаант өвчлөлийн орчин үеийн оношлогоо, эмчилгээг нэвтрүүлэх, иргэдэд харшлын тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, хүндрэлээс сэргийлэх, хүний нөөцийг бэхжүүлэх

2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа: Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.1.1. Харшлын эсрэг бодлого, хөтөлбөрийг боловсруулах, эрх зүй, санхүүгийн тогтвортой орчин бүрдүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.2. Харшлын анхдагч урьдчилан сэргийлэх чиглэлээр тоосжилтыг бууруулах, бүрхэвчгүй шороон хөрсийг таримал ургамлаар зүлэгжүүлэх, иргэд, аж ахуй нэгжийг мод тарих санаачлагыг дэмжих, харшил үүсгэдэггүй модыг сурталчлах, таниулах, "Шарилжгүй Даланзадгад" сум болох;

3.1.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үдийн цай, хоолонд харшил төрүүлэгч хүнсний бүтээгдэхүүнийг бууруулах, хориглох, мэргэжлийн зөвлөмжөөр хангах, хоол зүйчтэй байх боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллагын хяналтыг сайжруулах;

3.1.4. Хоол үйлдвэрлэлийн салбарын эрхлэгч, тогооч, ажилчдад хоолны харшил төрүүлэгч, харшлын шалтгаант хүнсний талаар мэдлэг хандлагын өөрчлөх сургалтуудыг хийх, ЭКО хоолыг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах;

3.1.5. Иргэд, сургууль, цэцэрлэг, бага насны хүүхдэд байгалийн пробиотик бүтээгдэхүүн (бүрсэн тараг, айраг, аарц) хэрэглэхийг дэмжих сургалт, сурталчилгаа хийх, "Сүү, тараг хөтөлбөр"-ийн хүрээнд пробиотик бүтээгдэхүүн цэсэд оруулах;

3.1.6. Иргэдийн дунд амьтны, ахуйн харшил төрүүлэгчээс сэргийлэх сургалт, сурталчилгаа хийх, гэрийн тэжээвэр амьтан худалддаг дэлгүүр, байгууллагыг зөвлөмжөөр хангах;

Хүрэх үр дүн: Харшил төрүүлэгч хүчин зүйлийг бүх талаар бууруулж, иргэдийн анхдагч урьдчилан сэргийлэлт, ногоон байгууламж, зүлэгжүүлэлт нэмэгдэж, иргэдийн эрүүл аж төрөх орчин сайжирсан байна.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.2.1. Өрх гэр, аж ахуйн нэгж, үйлчилгээний байгууллагад тамхигүй орчин бий болгох, тамхины цэг байгуулах, дам тамхидалтаас сэргийлэх, зөв соёлыг сурталчлах, мэдээлэх;

3.2.2. Хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийг дам тамхидалтад өртөхөөс сэргийлэх, хор уршгийг ойлгуулах, өсвөр насны хүүхэд, залуучуудад тамхины хор уршгийг сурталчлах;

3.2.3. Эхчүүдэд хүүхдээ хөхөөр хооллохын ач тусыг таниулах, сурталчлах, Харшлын эсрэг долоо хоногийг үр дүнтэй зохион байгуулах замаар иргэдийн мэдлэг хандлагыг дээшлүүлж харшлаас урьдчилан сэргийлэх;

3.2.4. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, бизнес эрхлэгчтэй хамтран иргэдийг эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, ахуйн хэрэглээний бодис, гоо сайхны бүтээгдэхүүний зөв зохистой хэрэглэх, төлөвшүүлэхэд мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах;

3.2.5. Иргэд, бага насны хүүхдийн антибиотикийн хэрэглээг бууруулах, антибиотикийг зөвхөн эмчийн заалтаар хэрэглэх мэдлэг, дадлыг төлөвшүүлэх сургалт, зөвлөмжөөр хангах сургалт, сурталчилгааг хийх;

3.2.6. Ард иргэдэд харшил, харшил төрүүлэгчийн талаар зөвлөгөө, зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд хийх, сурталчлах ажлыг зохион байгуулах;

Хүрэх үр дүн: Ард иргэдийн дунд харшлын анхдагч, хоёрдогч урьдчилан сэргийлэлт сайжирч, харшлаас сэргийлэх эрүүл мэндийн боловсрол нэмэгдэж, эрүүл орчинд зөв амьдрах дадал бий болсон байна.

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.3.1. 2 дугаар шатлалын эмнэлгийн харшлын төрөлжсөн мэргэжлийн эмч, сувилагчийг тасралтгүй сургах, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжих;

3.3.2. Эмч мэргэжилтэнг харшлын гуравдагч сэргийлэлтийн талаар мэдлэгийг дээшлүүлэх сургалт хийх, хүнс, эм, бусад харшлын талаар гарын авлага боловсруулах, хангах;

3.3.3. Харшилт урвалын хүндрэл, Анафилаксийн шокийн үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх мэдлэг, ур чадварыг сайжруулж, тусламж үйлчилгээний бэлэн байдлыг үнэлэх;

3.3.4. Бүх шатны эмч, мэргэжилтэнд харшил, харшлын шалтгаант өвчнөөс сэргийлэх, эмийн харшил, хордлого, эмнэлзүйн сургалтыг үе шаттай зохион байгуулах, иргэдэд харшлын сэдрэлээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх мэдлэг, ур чадварт сургах;

3.3.5. Харшлын ор ашиглалтыг сайжруулах, харшлын өдрийн эмчилгээний кабинет, нэгжийг бий болгох, лабораторийн тоног төхөөрөмжийн чадавхийг нэмэгдүүлэх, харшлын сорил хийж, орчин үеийн эмнэлзүйн удирдамж, эмчилгээг нэвтрүүлэх /sublingual immunotherapy, эмнэлзүйн uptodate программ/;

3.3.6. Харшлын шалтгаант өвчлөл, хяналтад буй иргэдийг бүртгэх, мэдээлэх, мэдээллийн бааз бүрдүүлэх;

3.3.7. Мэргэжлийн байгууллагатай хамтран Өмнөговь аймгийн бага насны хүүхдийн дунд харшлын шалтгаант өвчлөлийн тархалт, эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох, суурь судалгааг хийх;

Хүрэх үр дүн: Харшлын гуравдагч сэргийлэлт, оношлогоо эмчилгээ сайжирч, харшлын өвчлөл, хүндрэлээс сэргийлэх түүнээс шалтгаалсан нас баралтыг бууруулсан байна.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө

4.1. Аймгийн хэмжээнд харшил төрүүлэгчийг бууруулснаар ногоон байгууламж зүлэгжүүлэлт нэмэгдэж, иргэдийн эрүүл аж төрөх орчин сайжирна.

4.2. Ард иргэдийн харшил төрүүлэгчийн талаар мэдлэг дээшилж урьдчилан сэргийлэх боломжтой болно.

4.3. Иргэдийн харшлын шалтгаант сэргийлж болох өвчлөл, нас баралт буурч, гэр бүлд эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Тав. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт		Нэгж	Суурь түвшин (он)	Зорилтот түвшин (он)		Хэрэгжүүлэх байгууллага
				2020	2022	2024	
1.	Бохирдуулах бодисын бууралт PM2.5 тоосонцор		мкг/м³	138	110	100	УЦУОШТ, СЗД
2.	Бохирдуулах бодисын бууралт PM10 тоосонцор		мкг/м³	167	130	100	УЦУОШТ, СЗД
3.	Гэр хорооллын болон нийтийн эзэмшлийн нэмж зүлэгжүүлсэн талбай		га	9,9	12	15	БОАЖГ, СЗДТГ
4.	Хот, суурин газрын ногоон байгууламжийн талбай	Сум	га	293	308	353	БОАЖГ, СЗДТГ
5.	Жилд шарилжны тайралт хийсэн		тоо	0	2	3	ДЗСумын Хот тохижилт үйлчилгээ, иргэд
6.	Харшлын өвчнийг оношлох кабинет, тасаг		тоо	0	2	2	ЭМГ, БОЭТ
7.	Харшил өвчний сорил, оношлогоонд нэвтрүүлсэн		төрөл	1	2	2	ЭМГ, БОЭТ
8.	Арьс халим болон харшлын шалтгаант амьсгалын замын өвчлөл (10000 хүн амд)		промель	513,0	490,0	460,0	ЭМГ, БОЭТ
9.	Сургалтад хамрагдсан хоол, хүнс үйлдвэрлэлийн байгууллагын тоо		тоо	0	20	30	ЭМГ, Өрх сумын эмнэлэг
10.	Антибиотикийг жороор олгож буй эмийн сан		хувь	65	80	85	ЭМГ, Эмийн сангууд
11.	Харшлын нарийн мэргэжлийн эмчийн хангалт		тоо	1	2	3	ЭМГ, БОЭТ
12.	Харшлын сувилагчийн хангалт		тоо	0	1	2	ЭМГ, БОЭТ

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. Улсын болон орон нутгийн төсөв;

6.1.2. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив;

6.1.3. Бусад эх үүсвэр;

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн газар гүйцэтгэнэ.

7.2. Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагын дарга эрхлэгч нар хариуцан зохион байгуулна.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс хариуцан зохион байгуулна.

8.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс жил тутамд хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулна.

8.3. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.